



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Үл хөдлөх болон бусад үндсэн хөрөнгийг
балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,508,413,782.20 (нэг тэрбум таван зуун найман сая дөрвөн зуун арван гурван мянга долоон зуун наян хоёр төгрөг хорин) төгрөгийн балансын үнэ, 42,132,504.51 (дөчин хоёр сая нэг зуун гучин хоёр мянга таван зуун дөрвөн төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан албан контор (хуучин)-ын барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгийг Монголбанкинд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХӨЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
36 дугаар тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
МОНГОЛБАНКИНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон огноо /дахин үнэлсэн огноо/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Балансын нийт дүн /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1.Барилга байгууламж								
1	Конторын барилга /хуучин барилга, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, худалдааны гудамж 6-1/	2018/12/31	1,461,061,831.96	м.кв	1599	1,461,061,831.96	37,686,118.73	1,423,375,713.23
2	Дулааны шугам	2018/12/31	22,921,850.00	метр	35	22,921,850.00	856,276.07	22,065,573.93
3	Цахилгааны шугам	2018/12/31	6,066,720.00	метр	144	6,066,720.00	226,630.30	5,840,089.70
4	Цэвэр усны шугам	2018/12/31	1,976,800.00	метр	14	1,976,800.00	118,974.05	1,857,825.95
5	Бохир усны шугам	2018/12/31	13,545,220.00	метр	59	13,545,220.00	815,221.55	12,729,998.45
	Дүн					1,505,572,421.96	39,703,220.70	1,465,869,201.26
2.Бусад үндсэн хөрөнгө								
6	Зүлэгжүүлсэн талбай	2018/12/31	352,746.24	м.кв	37	352,746.24	63,690.25	289,055.99
7	Навчит мод	2018/12/31	7,077.50	ширхэг	2	14,155.00	1,095.38	13,059.62
8	Автомашинны хатуу хучилттай зогсоол	2001/01/01	998,000.00	ширхэг	3	1,996,000.00	1,996,000.00	-
9	Хайс /хашлага/	2018/12/31	57,579.50	м.кв	11	115,159.00	5,198.18	109,960.82
10	Асфальт талбай	2001/01/01	181,650.00	м.кв	12	363,300.00	363,300.00	-
	Дүн					2,841,360.24	2,429,283.81	412,076.43
	Нийт дүн					1,508,413,782.20	42,132,504.51	1,466,281,277.69